


Виза картыг ашиглан
Герман улсад аялах нь.



VISA | **GOLOMT BANK**
Investing for a brighter future

Виза карттай аялаарай

Виза картыг дэлхийн хэдэн сая байгууллага, газар хүлээн зөвшөөрдөг бөгөөд та хаана ч явсан аливаа саад хүндрэлгүйгээр, аюулгүй, хялбар байдлаар төлбөр тооцоо гүйцэтгэх боломжтой юм. Үүнээс гадна Виза картаар төлбөр хийхэд төрөл бүрийн онцгой урамшуулал, хөнгөлөлт таныг хүлээж байна.

Виза карттай аялаарай



Зочид буудал >



Автомашины түрээс >



Дэлгүүр >



Бусад хөнгөлөлт,
урамшуулал >

Зочид буудал

Тансаг зэрэглэлийн зочид буудлуудын сүлжээ нь зөвхөн Premium Виза карт эзэмшигчдэд зориулан аялалын дээд зэргийн урамшууллыг санал болгож байна.

Виза тансаг зэрэглэлийн зочид буудлуудын сүлжээ (Visa Luxury Hotel Collection)-гээр дамжуулан захиалга өгснөөр дараах 7 урамшуулалд хамрагдах боломжтой болно.

- Боломжит хамгийн бага үнийн баталгаа
- Өрөөний зэрэглэл шууд ахиулах боломж (боломжтой тохиолдолд)
- Wi-Fi-тай өрөө (боломжтой тохиолдолд)
- Өдөр бүр континенталь өглөөний хоол (буудлын үнэд багтсан)
- 25 ам.доллар бүхий хүнс, ундааны зүйлс авах эрх
- VIP зочны статус
- Өрөөгөө 15 цагт хүлээлгэн өгөх (боломжтой нөхцөлд)

Урамшуулалд хамрагдах эрх

Premium Виза карт нь тухайн улс орноос хамааран өөр өөр төрлийнх байдаг, тухайлбал Signature, Infinite, Platinum болон Голомт банкны Премьер болон Si картын бүтээгдэхүүн багтана. Тухайн бүс нутагт хэрэглэдэг картыг дараах линкээр орж үзнэ үү:

visaluxuryhotelcollection.com/eligibility


Хүчинтэй хугацаа: 2022/01/01 - 2022/12/31

Үйлчилгээний хугацаа, нөхцөл.
Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаас үзнэ үү.

Саналыг
хүлээн авах

VISA Visa Luxury
Hotel Collection

Тансаг зэрэглэлийн зочид буудал, ОНЦГОЙ санал



Зочид буудал

Agoda.com цахим хуудсаар захиалга өгч, Виза картаар төлбөр хийхдээ 10 хүртэл хувийн хөнгөлөлт эдлээрэй.


Тухайн зах зээлээс хамааран хөнгөлөлтийн хувь хэмжээ нь өөр өөр байна.

Бүх төрлийн Виза карт эзэмшигчдэд зориулсан хөнгөлөлт юм.

Хүчинтэй хугацаа: 2022/01/01 - 2022/12/31

Үйлчилгээний хугацаа, нөхцөл.
Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаас үзнэ үү.

Япон	Сингапур	Камбож
Хятад	Малайз	Энэтхэг
Хонг Конг	Тайланд	
Тайван	Индонез	
БНСУ	Филиппин	
Австрали	Вьетнам	



Зочид буудал

Hotels.com цахим хуудсаар захиалга өгч, Виза картаар төлбөр хийхдээ 8%*-ийн хөнгөлөлт эдлээрэй.

- Захиалгыг 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөс өмнө хийсэн байх
- Буудалд 2023 оны 3-р сарын 31-ний өдрөөс өмнө орсон байх

Бүх төрлийн Виза карт эзэмшигчдэд зориулсан хөнгөлөлт

Хүчинтэй хугацаа: 2022/01/01 - 2022/12/31

Хөнгөлөлт эдлэх код: Visa8

Үйлчилгээний хугацаа, нөхцөл.
Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаас үзнэ үү.

Саналыг
хүлээн авах



Зочид буудал

Booking.com цахим хуудсаар захиалга өгч, Виза картаар төлбөр хийхдээ захиалгынхаа 10 хүртэл хувийг буцаан аваарай.

Тухайн зах зээлээс хамааран хөнгөлөлтийн хувь өөр өөр байна.

Бүх төрлийн Виза карт эзэмшигчдэд зориулсан хөнгөлөлт.

Хүчинтэй хугацаа: 2022/02/01 - 2022/12/30

Үйлчилгээний хугацаа, нөхцөл.
Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаас үзнэ үү.

[Австрали](#)

[Индонез](#)

[Мьянмар](#)

[Шинэ Зеланд](#)

[Филиппин](#)

[БНСУ](#)

[Сингапур](#)

[Вьетнам](#)

[Тайван](#)


[Малайз*](#)

[Камбож](#)

[Хонг Конг](#)

[Тайланд](#)


Booking.com





Илүү их боломжийг бага үнээр

*Gold зэрэглэлд Голомт банкны Премьер болон Si картын бүтээгдэхүүн багтана.



Avis-с автомашин түрээсэлж 35 хүртэл хувийн хөнгөлөлт эдлээрэй.

Платинум, Премьер болон Si карт эзэмшигчдэд:

- Стандарт үнийг 20 хүртэл хувиар хямдруулна
- Олон улсын Leisure үнийг 10 хүртэл хувиар хямдруулна

Signature болон Infinite карт эзэмшигчдэд:

- Стандарт үнийг 35 хүртэл хувиар хямдруулна
- Олон улсын Leisure үнийг 30 хүртэл хувиар хямдруулна

Хүчинтэй хугацаа: 2022/01/01 - 2022/12/31

Үйлчилгээний хугацаа, нөхцөл.
Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаас үзнэ үү.

Саналыг
хүлээн авах

AVIS



Автомашин түрээслэхэд Hertz-с олгож буй онцгой хөнгөлөлт, давуу эрхийг эдлээрэй.

- АНУ, Канад, Европ*, Австрали, Шинэ Зеланд, Ази*-д автомат удирдлагатай автомашин түрээслэхэд 10%-ийн хэмнэлт (нэг өдрөөс дээш хугацаагаар түрээсийн захиалга өгсөн байх).
- Түрээсийн нэг өдрийн бэлэг (6/8 ба түүнээс дээш өдрийн түрээсийн захиалга өгсөн байх)
- Нэмэлт 10%-ийн хямдрал (6 ба түүнээс дээш өдрийн түрээсийн захиалга өгсөн байх)
- Автомашинны ангиллыг үнэ төлбөргүйгээр нэг зэрэглэл ахиулах боломж (5 ба түүнээс дээш өдрийн түрээсийн захиалга өгсөн байх)

Тус саналын хүчинтэй хугацаанд захиалга өгч, Виза картаар төлбөр хийснээр энэхүү хөнгөлөлт, давуу эрхийг эдлэх боломжтой юм.

Бүх төрлийн Виза карт эзэмшигчдэд зориулсан хөнгөлөлт.

Хүчинтэй хугацаа: 2022/01/01 - 2022/12/31

Хөнгөлөлт эдлэх код:

Захиалга өгөхдөө хөнгөлөлтийн дугаар CDP# 83181 болон урамшууллын купоны (PC) дугаарыг ашиглан давуу эрхээ эдлээрэй.

Үйлчилгээний хугацаа, нөхцөл.
Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаас үзнэ үү.



Автомашин
түрээс



Rentalcars.com
сайтаар автомашин
түрээслэх захиалга
өгч, Виза картаар
төлбөр хийхдээ
10%-ийн хөнгөлөлт
эдлээрэй.

Бүх төрлийн Виза карт эзэмшигчдэд зориулсан хөнгөлөлт.

Хүчинтэй хугацаа: 2022/07/01 - 2026/04/01

Үйлчилгээний хугацаа, нөхцөл.
Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаас үзнэ үү.

Саналыг
хүлээн авах

Rentalcars.com



Зочид буудал

Тансаг зэрэглэлийн зочид буудлуудын сүлжээ нь зөвхөн Premium Виза картын эзэмшигчдэд зориулан аялалын дээд зэргийн урамшууллыг санал болгож байна.

- Classic, Gold, Platinum болон Signature Виза карт эзэмшигчид Value Retail Villages*-с худалдан авалт хийж, Виза картаар төлбөр хийхэд 10%-ийг хэмнэх боломжтой юм.
- Дэлгэрэнгүй мэдээллийг холбогдох цахим хуудаснаас энд дарж авна уу. Infinite Виза карт эзэмшигчид Value Retail Villages*-с худалдан авалт хийж эсвэл "The Apartment"-ийн тусгайүйлчилгээ хүлээн авч, Виза картаар төлбөр хийгээд 10%-ийг хэмнэх болно. Дэлгэрэнгүй мэдээллийг холбогдох цахим хуудаснаас энд дарж авна уу

Тус санал нь Франкфурт, Мюнхен, Милан, Брюссель, Парис, Мадрид, Барселона, Лондон эсвэл Дублин зэрэг хотууд дахь Value Retail Villages-д хүчинтэй байна.

("Value Retail" гэж Value Retail Management компанийг хэлэх бөгөөд "Value Retail Villages" гэж тус компанийн ажиллуулдаг жижиглэнгийн худалдааны тансаг зэрэглэлийн дэлгүүрүүд/бүтик юм)

Хүчинтэй хугацаа: 2022/01/01 - 2022/12/31

Үйлчилгээний тодорхой нөхцөлтэй болно.

Бүх төрлийн Виза карт эзэмшигчид

Саналыг хүлээн авах


Infinite Виза карт эзэмшигчид

Саналыг хүлээн авах

VALUE RETAIL



Өөрийгөө баярлуулах, тайтгаруулах зорилгоор худалдан авалт хийхдээ ч ХЭМНЭЛТ гаргаж болно



Бусад хөнгөлөлт,
урамшуулал



Дэлхий даяар 450 чиглэлээр нислэг үйлддэг нисэх онгоцны буудал дахь хилийн хяналтын бүсийн Ногоон гарцаар гараарай

- Platinum Виза карт эзэмшигчдэд жижиглэнгийн үнийг 15%-иар хямдруулна
- Signature Виза карт эзэмшигчдэд жижиглэнгийн үнийг 20%-иар хямдруулна
- Infinite Виза карт эзэмшигчдэд жижиглэнгийн үнийг 25%-иар хямдруулна

* Аялал эхлэхээс 72 цагийн өмнө захиалга өгсөн байх ёстой

Platinum, Signature болон Infinite Виза карт эзэмшигчид тус эрхийг эдэлнэ.


Хүчинтэй хугацаа: 2022/01/01 - 2022/12/31

Үйлчилгээний хугацаа, нөхцөл.
Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаас үзнэ үү.

Саналыг
хүлээн авах



Чухал эрх, хэрэгтэй урамшуулал



Бусад хөнгөлөлт,
урамшуулал




Виза Консейрж нь 24/7 цагийн хувийн дижитал туслах, амьдралын хэв маягийн хөтөч юм

- Өргөн сонголт бүхий хоол захиалах онцгой санал, аливаа хязгаарлалтгүй давуу эрх
- Эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээ
- Чөлөөт цагаа зугаатай өнгөрүүлэх газар, боломж
- Чөлөөт цагаа гэртээ зугаатай өнгөрүүлэх, тухайн орон нутаг болон бусад улсад зохион байгуулагдаж буй арга хэмжээнд оролцох, хамрагдах талаар зөвлөгөө авах боломж
- Бэлэг дурсгалын зүйлс болон бусад худалдан авалтын талаар туслалцаа, зөвлөгөө авах боломж
- Бизнесийн үйл ажиллагаа, гэр, зам дагуух газруудын талаар мэдээлэл өгөх, туслах тусгай үйлчилгээ
- Гуравдагч талын чат аппликэйшнийг ашиглах боломж (8 орон: Сингапур, Малайз, Хонг Конг, Австрали, Энэтхэг, Япон, Тайван, БНСУ)

Infinite, Signature Виза карт эзэмшигчид болон зарим Platinum Виза карт эзэмшигчид дээрх урамшуулал, эрхийг эдлэх боломжтой юм.

Саналыг
хүлээн авах

VISA Concierge



Үйлчилгээний нөхцөл

Виза тансаг зэрэглэлийн зочид буудлуудын сүлжээ (Visa Luxury Hotel Collection)-ний санал:

Виза корпораци (цаашид “Виза” гэх)-н үйлчилгээний нөхцөл, хугацаа

- Саналын хүчинтэй хугацаа: 2022/01/01 –2022/12/31.
- Саналын хэрэгжилт нь тухайн захиалгын үеийн боломжоос шалтгаална.
- Санал нь оролцогч зочид буудлуудад хамаарна.
- Зөвхөн Ази Номхон далайн бүс нутаг, Төв Европ, Ойрхи Дорнод, Африкийн улс орнуудад гаргасан Infinite болон Signature Виза карт, Вьетнам, Хятад, Австрали, Шинэ Зеланд, Төв Европ, Ойрхи Дорнод, Африкийн улс орнуудад гаргасан Platinum Виза карт эзэмшигчид www.visaluxuryhotels.com цахим хуудсаар захиалга өгч, Premium Виза картын тусгай урамшуулал, хөнгөлөлт эдлэх боломжтой юм.
- Үйлчлүүлэгч хугацаа нь хүчинтэй, шаардлага хангасан Виза картаар төлбөр хийсэн тохиолдолд энэхүү санал хүчинтэй байна.
- Боломжит хамгийн бага үнийн баталгаа нь хөнгөлөлттэй үнэд хамаарахгүй бөгөөд түүнийг бусад төрлийн саналтай нэгтгэх боломжгүй юм.
- Өдөр бүрийн континенталь өглөөний хоолыг нэг өрөөнд байрласан хоёр хүнээр тооцдог болно.
- Хүнс, ундааны зүйлс авах эрхийн тооцоог бэлэн бусаар, өрөө тус бүрээр хийнэ.
- Карт эзэмшигч нь холбогдох бүх татвар, үйлчилгээний хураамж, төлбөр болон зочид буудалд гарч болзошгүй бусад зардал, төлбөрийг хариуцна.
- Хуулиар хориглосон, хязгаарласан тохиолдолд хүчингүй болно.
- Санал болгож буй үйлчилгээг тэр чигээр нь харилцагчдад хүргэхийн тулд Виза хүчин чармайлт гаргах бөгөөд карт эзэмшигчдэд санал болгосон үйлчилгээг огт үзүүлээгүй эсвэл санал болгосон байдлаар үзүүлээгүй (зочид буудал эсвэл Визагийн алдаа буюу хайхрамжгүй байдлаас шалтгаалсан) тохиолдолд карт эзэмшигчид Визагийн эсрэг аливаа нэхэмжлэл гаргахгүй, нөхөн төлбөр шаардахгүй болно.
- Виза нь (а) карт эзэмшигчид зочид буудлын санал болгож буй аливаа үйлчилгээ авах, авах оролдлого хийх, эсвэл (б) зочид буудал нь ямар нэгэн шалтгаанаар санал болгосон үйлчилгээг үзүүлэхээс татгалзах, үзүүлэх боломжгүй байх, тус үйлчилгээтэй холбоотой хөнгөлөлт, давуу эрхийг олгохоос татгалзах, эсхүл олгохгүй байх зэргээс шалтгаалан гарч болох аливаа алдагдал, хохирлыг ямар ч байдлаар хариуцахгүй болно.
- Виза нь урьдчилан мэдэгдэл гаргахгүйгээр, хэдийд ч аливаа саналын хугацаа, нөхцөлийг цуцлах болон/эсвэл өөрчлөх бүрэн эрхтэй байна.
- Оролцогч зочид буудлууд нь урьдчилан мэдэгдэл гаргахгүйгээр хөтөлбөрөөс гарч, урамшуулал, хөнгөлөлтийг цуцлах эрхтэй.
- Виза болон оролцогч зочид буудлууд энэхүү саналын хугацаа, нөхцөлийг ялгаатай тогтоох эрхтэй болно.
- Оролцогч зочид буудлуудын шинэчилсэн жагсаалтыг www.visaluxuryhotels.com цахим хуудсаас буюу дэлгэрэнгүй мэдээллийг Visa Concierge руу залган авах боломжтой юм.

Боломжит хамгийн бага үнийн баталгаа:

Виза тансаг зэрэглэлийн зочид буудлуудын сүлжээгээр дамжуулан захиалга өгөхөд бид нар олон нийтэд нээлттэй хамгийн бага үнийг санал болгож байгаагаа баталж байна.

Та захиалга өгснийхөө дараа 24 цагийн дотор өөр цахим хуудсаас илүү хямд үнэ* олсон тохиолдолд бид үнийг тохируулан өөрчлөх болно.

Илүү хямд үнэ нь дараах нөхцөлтэй байна. Үүнд:

- Захиалга өгөхөд тавих шаардлага, төлбөр хийх болон цуцлах бодлого, журам нь Виза тансаг зэрэглэлийн зочид буудлуудын сүлжээгээр өгсөн таны захиалгатай адил байх,
- Зочид буудал, өрөөний ангилал, байх хугацаа, зочдын тоо нь ижил байх,
- Бусад цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулсан, шалгаж нягтлах боломжтой байх.
- Бусад урамшуулал буюу хөнгөлөлтийг тооцохгүйгээр зөвхөн өрөөний үнэ байх.

Өрөөний үнийг тохируулан өөрчлөх үйл ажиллагаа:

- Хүсэлт гаргахын тулд захиалга өгснөөс хойш 24 цагийн дотор манай Боломжит хамгийн бага үнийн баталгааны онлайн маягтыг бөглөнө. Бид нар таны хүсэлтийг судалж, 48 цагийн дотор тантай эргээд холбогдох болно.
- Манай зочид буудлуудын захиалга цуцлах бодлого нь хоорондоо ялгаатай юм. Гэхдээ ихэнх нь уян хатан бодлоготой бөгөөд буудалд орохоос 24 цагийн өмнө захиалгыг цуцалж болдог байна. Аялалын төлөвлөгөө өөрчлөгдөх тохиолдол гардаг гэдгийг Виза тансаг зэрэглэлийн зочид буудлуудын сүлжээ нь хүлээн зөвшөөрдөг тул захиалга цуцалсны төлбөр, хураамжийг авдаггүй болно.

Боломжит хамгийн бага үнийн баталгааны нөхцөл:

- Виза тансаг зэрэглэлийн зочид буудлуудын сүлжээ нь оролцогч зочид буудлууд олон нийтэд нээлттэй хамгийн бага үнийг дараах нөхцөлд санал болгож буйг баталж байна:
- Захиалга өгснөөс хойш 24 цагийн дотор Боломжит хамгийн бага үнийн баталгааны онлайн маягтыг бүрэн гүйцэд бөглөсөн байх.
 - Хүсэлтэд илүү бага үнийн дүн болон түүнийг нотлох боломжтой линкийг (URL) оруулсан байх.

Дараах үнэ шаардлагад нийцэхгүй болно, тухайлбал:

- Урьдчилан төлсөн, цуцлагдахгүй ба/эсвэл буцаан олгогдохгүй нөхцөлтэй үнэ.
- Дуудлага худалдааны үнэ эсвэл Priceline, Hotwire зэрэг флаш борлуулалтын цахим хуудсанд байршуулсан үнэ (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй).
- Урамшууллын хөтөлбөрийн үнэ, компани/бүлэгт хамаарах үнэ, засгийн газраас тогтоосон үнэ болон/эсвэл олон нийтэд зориулагдагүй үнэ.
- Онгоцны тийз, автомашины түрээс, шоу үзүүлбэрийн тасалбар зэрэг аялалын болон/эсвэл зугаа цэнгээний бусад бараа, үйлчилгээний үнийг багтаасан өрөөний багц үнэ.
- Илүү хямд үнэ нь нотлогдсон тохиолдолд таны өрөөний хоногийн үнийг тохируулан өөрчлөх болно.
- Тухайн үнэ болон/эсвэл урамшуулал, хөнгөлөлтийг зочид буудлын тусгай санал, урамшууллын багц буюу олон нийтэд мэдээлээгүй бусад үнэтэй нэгэн зэрэг хэрэглэх боломжгүй юм.
- Виза тансаг зэрэглэлийн зочид буудлуудын сүлжээ нь тухайн хүсэлтийг дангаараа шийдвэрлэх эрхтэй.
- Виза тансаг зэрэглэлийн зочид буудлуудын сүлжээ нь өрсөлдөхүйц үнийг бодитоор санал болгож буйг тогтоох эрхтэй.
- Маргаан гарсан тохиолдолд Виза тансаг зэрэглэлийн зочид буудлуудын сүлжээний шийдвэр эцсийнх байна.
- Виза тансаг зэрэглэлийн зочид буудлуудын сүлжээ нь энэхүү Боломжит хамгийн бага үнийн баталгааг хэдийд ч өөрчлөх эрхтэй.

Буудалд буусны дараа өөрөөгөө автоматаар сайжруулах боломж:

Зочид буудалд ийм боломж, өрөө байгаа эсэхээс хамаарна. Зочид буудалд бүртгүүлсний дараа таны өрөөний зэрэглэлийг ахиулан сайжруулна.

Wi-Fi-тай өрөө:

Зочид буудалд байрлах хугацааны туршид өрөөндөө үнэгүй интернэт хэрэглэнэ (боломжтой тохиолдолд).

Үйлчилгээний нөхцөл

Өдөр бүр континенталь өглөөний хоол зооглох эрх:

Зочид буудалд байрлах хугацаанд та болон таны нэг зочин өдөр бүр үнэ төлбөргүй континенталь өглөөний хоол зооглох болно. Зочид буудал нь континенталь өглөөний хоол санал болгодоггүй тохиолдолд тухайн орон нутгийн зах зээлийн үнийг үндэслэн өөр төрлийн хоол буюу ижил үнэ бүхий урамшуулал танд санал болгоно.

25 ам.доллар бүхий хүнс, ундааны зүйлс авах эрх:

Та зочид буудалд бүртгүүлэхдээ 25 ам. долларын (эсвэл түүнтэй тэнцэх үндэсний мөнгөн тэмдэгтээр тооцсон) хүнс, ундааны эрхийн бичиг авах эсвэл буудлаас гарах үед 25 ам. доллар (эсвэл түүнтэй тэнцэх үндэсний мөнгөн тэмдэгтээр тооцсон) хөнгөлөлт эдлэх болно. Таны зочид буудалд байрлах хугацаанд нэг өрөөнд ногдох хөнгөлөлт буюу эрхийн бичиг 25 ам.долларын (эсвэл түүнтэй тэнцэх үндэсний мөнгөн тэмдэгтээр тооцсон) хязгаартай байна. Зочид буудалд байрлах хугацаа гэж зочид буудалд бүртгүүлэх, буудлаас гарах үйл явцаас үл хамааран нэг зочид буудалд дараалан хоносон хоногийг хэлнэ. Дээр дурдсан хязгаарт хэмжээнээс хэтэрсэн аливаа төлбөрийг буудлаас гарах үедээ та хариуцан төлөх болно. Энэхүү эрх, хөнгөлөлт нь бэлэн мөнгөний үнэ цэнийг агуулаагүй бөгөөд өрөөний үнэ эсвэл гуравдагч этгээдийн үйлчилгээнд үйлчлэхгүй болно.

VIP зочны статус:

Виза тансаг зэрэглэлийн зочид буудлуудын сүлжээний зочны хувьд таныг VIP зочноор хүлээн авна. Тухайн зочид буудлаас хамааран VIP зочны үйлчилгээ болон өрөө нь адилгүй байна.

Өрөөгөө 15 цагт хүлээлгэн өгөх боломж:

Зочид буудлын боломжоос хамааран хүсэлт гаргасны дагуу буудлаас гарах хугацааг хойшлуулж болно. Бүртгүүлэх үед эсвэл байх хугацаандаа та Хүлээх авах үйлчилгээний ажилтнуудад хүсэлтээ илэрхийлж, буудлаас гарах хугацааг 15 цаг хүртэл хойшлуулах боломжтой юм.

* Зочид буудал нэг буюу хэд хэдэн урамшуулал, хөнгөлөлтийг үзүүлэх боломжгүй тохиолдолд ижил үнэ бүхий өөр төрлийн урамшуулал, хөнгөлөлтийг олгож болох юм. Зарим зочид буудалд захиалсан өрөөний стандартад зарим давуу тал, урамшуулал багтсан байдаг. Ийм тохиолдолд зочид буудал нь ижил үнэ бүхий өөр төрлийн урамшуулал, хөнгөлөлтийг үзүүлж эсвэл үзүүлэхгүй байж болно. Амралтын газар аливаа давуу эрх эдлэхээр төлсөн төлбөрийг буцаан олгох боломжгүй юм. Виза тансаг зэрэглэлийн зочид буудлуудын сүлжээний цахим хуудас буюу Виза Concierge-ээр дамжуулан захиалга өгсөн тохиолдолд хөнгөлөлт, урамшууллыг хүртэх боломжтой болно. Зарим зочид буудалд нэмэлт урамшуулал авахын тулд доод тал нь нэг өдрийн захиалга өгөх буюу тодорхой ангиллын өрөө захиалах шаардлагатай байдаг байна. Зочид буудал тус бүрийн нөхцөлтэй танилцах нь зүйтэй юм.

Agoda.com-н санал:

Урамшуулал / Хөтөлбөрийн хугацаа 2021/12/01 – 2025/12/31

Урамшуулал

Оролцогч улс орон/бүс нутагт олгосон аливаа Виза карт эзэмшигчид. Хятад (эх газрын), Япон, Өмнөд Солонгос, Хонконг, Тайвань, Австрали, Шинэ Зеланд, Сингапур, Малайз, Тайланд, Индонез, Филиппин, Вьетнам, Камбож, Энэтхэг.

Урамшуулал / Хөтөлбөрийн танилцуулга

Карт эзэмшигчид картыг олгосон орны цахим хуудсаар захиалга өгч, зочид буудлын хөнгөлөлт болон/эсвэл хөнгөлөлт, урамшууллын багцыг авах боломжийг олгох хамтарсан брендийн цахим хуудсыг Agoda хийх гэж байна (Agoda-н бодлого, үйлчилгээний нөхцөлтэй уялдсан байх болно). Agoda өөрийн үйлчилгээ эсвэл цахим хуудасны хувьд ямар нэгэн баталгаа гаргахгүй бөгөөд энэ нь "одоо байгаа" болон "боломжтой" үйлчилгээ гэсэн зарчимтай холбоотой юм. Холбогдох цахим хуудсаар зохих захиалгыг эрх бүхий Виза картаар хийсэн тохиолдолд л урамшууллын эрх үүснэ.

Зориулалтын цахим хуудас:

Япон www.agoda.com/visaip
Эх газрын Хятад www.agoda.com/visacn
Хонг Конг www.agoda.com/visahk
Тайвань www.agoda.com/visatw
Өмнөд Солонгос www.agoda.com/visakorea
Австрали www.agoda.com/visaau
Сингапур www.agoda.com/visasg
Малайз www.agoda.com/visamy
Тайланд www.agoda.com/visath
Индонез www.agoda.com/visaid
Филиппин www.agoda.com/visaph
Вьетнам www.agoda.com/visavn
Камбож www.agoda.com/visakh
Энэтхэг www.agoda.com/visain

- Австрали, Шинэ Зеланд улс тус бүрт (а) Дотоод захиалга хийсэн тохиолдолд (карт гаргасан оронд захиалга өгөхөд): тухайн орны зочид буудлын захиалгаас 10%-ийн хөнгөлөлт; эсвэл дотоодын " захиалгын багц "-с 5%-ийн хөнгөлөлт эдэлнэ (тухайлбал, онгоц болон буудлын захиалгын багц)*. (б) Олон улсын гүйлгээ бол (картыг гаргаснаас өөр улс оронд захиалга хийсэн): зочид буудлын захиалгын дүнг 8%-иар; эсвэл захиалгын багцыг 4%-иар хямдруулна.
- Япон, Малайз, Филиппин, Индонез улс тус бүрт (бүх гүйлгээг олон улсын гүйлгээ гэх) - зочид буудлын захиалгаас 8%-ийн хөнгөлөлт өгч эсвэл захиалгын багцыг 4%-иар хямдруулна.
- Өмнөд Солонгост (бүх гүйлгээг олон улсын гүйлгээ гэх) - зочид буудлын захиалгаас ᠖%-ийн хөнгөлөлт өгч эсвэл захиалгын багцыг 3%-иар хямдруулна.
- Вьетнамд (бүх гүйлгээг олон улсын гүйлгээ гэх) - зочид буудлын захиалгаас 7%-ийн хөнгөлөлт өгч эсвэл захиалгын багцыг 3%-иар хямдруулна.
- Камбож, Тайваньд (бүх гүйлгээг олон улсын гүйлгээ гэх) - зочид буудлын захиалгыг 8%-иар эсвэл захиалгын багцыг 3%-иар хямдруулна.
- Эх газрын Хятад, Хонг Конг, Сингапурт (бүх гүйлгээг олон улсын гүйлгээ гэх) - зочид буудлын захиалгын дүнг 7%-иар эсвэл захиалгын багцыг 3%-иар хямдруулна.
- Тайланд-д (бүх гүйлгээг олон улсын гүйлгээ гэх) - зочид буудлын захиалгын дүнг 5%-иар эсвэл захиалгын багцыг 3%-иар хямдруулна.
- Энэтхэгт зочид буудлын захиалгын дүнг 7%-иар эсвэл захиалгын багцыг 3%-иар хямдруулна.

Үйлчилгээний нөхцөл

Hotels.com-н санал:

Оролцогч зочид буудалд захиалга өгөхдөө захиалах эхний өрөөний үнийг 8%-иар хямдруулахын тулд энэхүү купоныг ашиглана.

Та захиалга өгөхдөө буудлын төлбөрийг төлөх ёстой. Хөнгөлөлт нь захиалгын зөвхөн эхний өрөөнд хамаарна. Та бусад өрөөний төлбөрийг бүрэн хэмжээгээр нь төлөх шаардлагатай болно. Энэхүү хөнгөлөлт нь аливаа татвар, хураамж, нэмэлт зардалд хамаарахгүй.

Энэ купоныг ашиглахын тулд та 18-аас дээш настай, карт олгосон улсад оршин суугч байх ёстой. Та энэ купоныг зөвхөн 2022 оны 4-р сарын 1-ний өдрөөс 2022 оны 12-р сарын 31-ний өдрийг дуусталх хугацаанд Hotels.com/visa цахим хуудсаар захиалга өгөхдөө ашиглах боломжтой юм (ингэхдээ буудалд байрлах хугацаа нь 2023 оны 3-р сарын 31-ний өдөр дуусгавар болох ёстой). Захиалга нь тухайн зочид буудлын үйлчилгээний нөхцөл, боломжоос хамаарна.

Энэхүү купоныг дараах тохиолдолд ашиглах боломжгүй юм:

- Hotels.com-ын урамшууллын хөтөлбөрт хамрагдахад
- Захиалгын багц авах, тухайлбал зочид буудал + нислэг
- Групп Аялал жуулчлалын үйлчилгээгээр дамжуулан захиалга хийх
- Захиалгын төлбөрийг зочид буудалд төлөх
- Захиалгын төлбөрийг гадаад валютаар хийх
- Оролцогч бус зочид буудалд захиалга өгөх
- Энэхүү купоныг хүлээн авахаас өмнө захиалга өгөх

Оролцогч бус зочид буудлуудын жагсаалтыг https://www.hotels.com/page/hotel-exclusions-арac/?pos=HCOM_ASIA&locale=en_ASIA хаягаар орж үзнэ үү. Оролцогч зочид буудлуудын жагсаалт хэдийд ч өрчлөгдөж болно.

- Та энэхүү купоныг таван удаа захиалга хийхэд ашиглах боломжтой бөгөөд захиалга хийх бүрт бүрэн хэмжээгээр нь ашиглах ёстой. Таван захиалга хийсний дараа та нэг буюу хэд хэдэн захиалгыг цуцалсан ч энэхүү купоныг дахин ашиглах боломжгүй болно.
- Та захиалга хийж дуусахаас өмнө купон хүчинтэй байгаа эсэхийг шалгах боломжтой юм. Нэг захиалгад нэг купоныг л ашиглаж болно.
- Энэхүү купоныг Hotels.com цахим хуудас дахь хямдруулсан үнэтэй хамт нэг дор хэрэглэж болно. Гэхдээ купоныг Hotels.com-ын бусад урамшуулалтай (гуравдагч этгээдээс санал болгож буй эсвэл бусад) хамт ашиглах боломжгүй.
- Та энэ купоныг ашиглахдаа Hotels.com™ урамшууллын оноо цуглуулах эсвэл үүнтэй холбоотой урамшуулалд хамрагдах боломжгүй юм.
- Зөвшөөрснөөс илүү зочдыг байрлуулсны төлбөр, утсаар ярьсны төлбөр, цуцлалтын хураамж, зогсоолын болон бусад төлбөр зэрэг татвар, хураамж, төлбөр төлөхөд энэ купоныг ашиглах боломжгүй. Та эдгээр төлбөрийг захиалга өгөхдөө эсвэл зочид буудалд байрлаж байхдаа төлөх болно.
- Та энэ купоныг бэлэн мөнгөнд хөрвүүлэх, шилжүүлэх эсвэл худалдах боломжгүй юм.
- Хуулиар хориглосон тохиолдолд хүчингүй болно. Купоныг зүй бусаар ашиглахыг хориглох бөгөөд хэрэв зүй бусаар ашигласан бол залилан гэж үзнэ. Бид энэхүү саналыг хэдийд ч өөрчлөх, буцаах эрхтэй бөгөөд купоныг ашиглан үнэ өсөх, эрэлт нэмэгдэх үед буцаан худалдах зорилгоор хуурамч захиалга хийсэн тохиолдолд тус захиалгыг цуцлах эрх эдэлнэ.
- Захиалгын ердийн нөхцөлийг хэрэгжүүлэх ([hotels.com/customer_care/terms_conditions.html](https://www.hotels.com/customer_care/terms_conditions.html)-г үзнэ үү) бөгөөд бүх захиалга нь зочид буудлын боломжтой байдлаас хамаарна.
- Hotels.com нь энэхүү саналыг хэрэгжүүлнэ.
- Эдгээр нөхцөлийг Вашингтон мужийн хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

Виза үйлчилгээний нөхцөл

Холбогдох хууль тогтоомжоор зөвшөөрсөн дээд хэмжээний хүрээнд Виза нь (а) Hotels.com-ын аливаа санал эсвэл аливаа үйлчилгээг ашиглах, ашиглах оролдлого хийх, эсвэл (б) Hotels.com нь ямар нэгэн шалтгаанаар гаргасан саналыг хэрэгжүүлэхгүй байх эсвэл хэрэгжүүлэхээс татгалзах, саналд тусгагдсан урамшуулал, хөнгөлөлтийг олгохоос татгалзах, үзүүлэх боломжгүй байх, тус үйлчилгээтэй холбоотой хөнгөлөлт, давуу эрх олгохоос татгалзах, эсхүл олгохгүй байх зэргээс шалтгаалан гарч болох аливаа алдагдал, хохирол, нэхэмжлэлийн хариуцлагыг ямар ч байдлаар хариуцахгүй болно. Виза болон Hotels.com нь урьдчилан мэдэгдэл гаргахгүйгээр, хэдийд ч аливаа санал болон үйлчилгээний нөхцөлд өөрчлөлт оруулах буюу цуцлах эрхтэй болно.

Үйлчилгээний нөхцөл

Booking.com-н санал:

Booking.com болон Виза Бэлэн мөнгөөр олгох 10 хүртэл хувийн буцаалт

Виза карт эзэмшигчид нь буудлын захиалгын 6%-10%-ийг бэлэн мөнгөөр буцаан авах боломжтой юм.

- 1-р алхам: Booking.com-д бүртгүүлэх
- 2-р алхам: Бэлэн мөнгө буцааж авах тэмдэг бүхий буудлын захиалга өгөх
- 3-р алхам: Хүчинтэй Виза картаар захиалга хийж, төлбөр төлөх

Үйлчилгээний нөхцөл

Энэхүү санал нь бүх төрлийн Виза карт эзэмшигчдэд хүчинтэй ("Виза карт эзэмшигчид") байна.

Booking.com/VisaXYZ* цахим хуудсаар дараах үе шаттайгаар захиалга өгөх ёстой.

- Бүртгүүлэх эсвэл бүртгүүлсэн хаягаараа Booking.com цахим хуудсанд орох
- Үнэ болон бэлэн мөнгөний буцаан олголтыг харахын тулд тохиромжтой буудал, аялалын огноо, өрөөний төрлийг сонгох
- Захиалгаа дуусгахын тулд шаардлага хангасан зохих Виза картыг ашиглах
- Booking.com аппликейшнээр хийсэн захиалга энэхүү урамшуулалд хамрагдахгүй.
- Цуцалсан болон "харуулахгүй" захиалгыг тус урамшуулалд тооцохгүй
- Буудлаас гарснаас хойш ажлын 67 ба түүнээс дээш өдрийн дараа буцаан олголт хийгдэнэ. Карт эзэмшигчид Booking.com –ын "Урамшуулал ба түрийвч" ("Rewards & Wallet") хэсгээс бэлэн мөнгөний буцаан олголтын төлөвийг шалгах боломжтой юм.
- Бэлэн мөнгийг Booking.com цахим хуудасны "Урамшуулал ба түрийвч" ("Rewards & Wallet") хэсэгт оруулж бүртгүүлсэн картны дансанд шилжүүлнэ. Profile > Rewards & Wallet хэсэгт энэхүү мэдээллийг харж болно.
- Картаар төлбөр хүлээн авдаггүй захиалгад тус санал нь хамаарахгүй. Эдгээр захиалгад зөвхөн бэлэн мөнгөөр төлбөр хийдэг ба бэлэн мөнгө буцааж авах тэмдэггүй буудлын захиалга багтана.
- Захиалга хийх үед урамшууллын бүх нөхцөлийг хангасан байх ёстой. Аливаа буцаах хүсэлтийг хүлээн зөвшөөрөхгүй.
- Саналын талаар асууж лавлах зүйл байвал Booking.com-ын Харилцагчын үйлчилгээ (Customer Service)-тэй (**www.booking.com/content/contact-us.html**) холбогдож болно.
- Booking.com болон/эсвэл Виза нь үйлчилгээний нөхцөлийг хэдийд ч өөрчилж болно.
- Санал нь Booking.com-ын үйлчилгээний нөхцөлтэй уялдсан байна. Маргаан гарсан тохиолдолд Booking.com болон Виза-н шийдвэр эцсийнх байна.
- Англи болон бусад хэл дээрх хувилбаруудын хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хэл дээрх хувилбарыг баримтална.

*URL нь тухайн зах зээлээс хамаарна (жишээ нь. Booking.com/VisaSG, Booking.com/VisaMY).

Avis-н санал:

Avis нь автомашин түрээслэхэд 35 хүртэлх хувийн хөнгөлөлтийг Gold, Platinum, Signature, Infinite Виза карт эзэмшигчдэд үзүүлж байгаадаа баяртай байна. www.avisworld.com/visa хаягаар захиалга өгч, хөнгөлөлтийг автоматаар шууд авах эсвэл Avis Preferred буюу Avis President's Клуб-д Премиум Виза харилцагчаар бүртгүүлж, өөрийн профайлтай холбоотой урамшууллыг авч болно.

Премьер, Si болон Platinum карт эзэмшигчдэд:

- Стандарт үнийг 20 хүртэл хувиар хямдруулна
- Олон улсын Leisure үнийг 10 хүртэл хувиар хямдруулна

Signature болон Infinite карт эзэмшигчдэд:

- Стандарт үнийг 35 хүртэл хувиар хямдруулна
- Олон улсын Leisure үнийг 30 хүртэл хувиар хямдруулна

Давуу эрхтэй түншийн хөнгөлөлт нь зөвхөн Европ, Африк, Ойрхи Дорнод, Азийн оршин суугчид түрээсийн үйлчилгээ авахад нь хамаарна. Хөнгөлөлтийг эдлэхийн тулд Виза AWD (Avis Worldwide Discount) дугаарыг ашиглан захиалга өгөх ёстой.

www.avisworld.com/visa цахим хуудсаар захиалга хийхэд эдгээр AWD-г автоматаар кодчилох болно, хэрэв өөр сувгаар захиалах бол зөв AWD-ийг оруулах шаардлагатай юм:

Infinite Виза	E438500
Signature Виза	K738800
Platinum Виза	O368100
Премьер, Si Виза	W819200

Хөнгөлөлтийг захиалгын үед эдлэх боломжтой бөгөөд түрээсийн хугацаа, миль, даатгалд хамаарна. Шууд худалдаж авах боломжтой туслах бараа бүтээгдэхүүнд хөнгөлөлт үзүүлэхгүй.

Тусгай үнэ, брокерийн үнэд хөнгөлөлт хамаарахгүй, микроавтобус, Prestige, Select зэрэг тусгай паркийн автомашин болон жолоочтой машин түрээслэхэд хөнгөлөлт үзүүлэхгүй.

Avis-с автомашин түрээслэх стандарт нөхцөлийг мөрдөнө.

Үйлчилгээний нөхцөл

Hertz-н санал:

1-р санал: автомат удирдлагатай автомашин түрээслэхэд 10%-ийн хэмнэлт (нэг өдрөөс дээш хугацаагаар түрээсийн захиалга өгсөн байх).

- Хөнгөлөлт авахын тулд түрээсийн захиалга өгөхдөө карт эзэмшигчид хөнгөлөлтийн дугаар буюу CDP#82181 ашиглана.
- Захиалга өгөх, автомашиныг авах саналын хүчинтэй хугацаа нь өнөөдрөөс эхлэн 2022/12/31 хүртэл байна.
- Санал нь зөвхөн Австрали, Шинэ Зеланд, Европ*, Ази^, АНУ болон Канад дахь оролцогч газруудад Hertz-н боломжит үнээр (leisure жижиглэнгийн худалдааны үнэ) автомат удирдлагатай автомашин түрээслэхэд хүчинтэй байна.
- Санал нь Hertz Collections-аас бусад бүх машины бүлэгт хамаарна

*Европ: Бельги, Франц, Герман, Итали, Люксембург, Нидерланд, Испани болон Их Британи, Ази: Бруней, Камбож, Хонг Конг, Малайз, Пакистан, Филиппин, Сингапур, Өмнөд Солонгос, Шри Ланка, Тайвань, Тайланд, Вьетнам.

2-р санал: Түрээсийн нэг өдрийн бэлэг (6/8 ба түүнээс дээш өдрийн түрээсийн захиалга өгсөн байх)

- Хөнгөлөлт авахын тулд карт эзэмшигчид тухайн орны урамшууллын купоны (PC) дугаарыг ашиглана.
- Санал нь зөвхөн Европ*, Ази^, АНУ болон Канад дахь оролцогч газруудад Hertz-н боломжит үнээр (leisure жижиглэнгийн худалдааны үнэ) автомашин түрээслэхэд хүчинтэй байна.
- Европ болон Азид 6 ба түүнээс дээш өдрийн түрээсийн захиалга өгсөн байх (бэлэглэсэн 6 дахь өдрийг оролцуулан тооцно).
- АНУ болон Канадад 8 ба түүнээс дээш өдрийн түрээсийн захиалга өгсөн байх (бэлэглэсэн 8 дахь өдрийг оролцуулан тооцно).
- Хөнгөлөлтийг дараах автомашины бүлэгт хэрэглэнэ:
- Европт*: Дунд болон том оврын
- Азид^: Бүх төрлийн автомашин
- АНУ/Канадад: Том оврын, хүнд даацын

*Европ: Бельги, Франц, Герман, Итали, Люксембург, Нидерланд, Испани болон Их Британи ^Ази: Бруней, Камбож, Хонг Конг, Малайз, Пакистан, Филиппин, Сингапур, Өмнөд Солонгос, Шри Ланка, Тайвань, Тайланд, Вьетнам.

3-р санал: Нэмэлт 10%-ийн хямдрал (6 ба түүнээс дээш өдрийн түрээсийн захиалга өгсөн байх)

- Хөнгөлөлт авахын тулд карт эзэмшигчид тухайн орны урамшууллын купоны (PC) дугаарыг ашиглана.
- Санал нь зөвхөн Австрали болон Шинэ Зеланд дахь оролцогч газруудад Hertz-н боломжит үнээр (leisure жижиглэнгийн худалдааны үнэ) автомашин түрээслэхэд хүчинтэй байна.
- Түрээсийн хугацаа 6 өдрөөс дээш байна.

4-р санал: Автомашины ангиллыг үнэ төлбөргүйгээр нэг шатаар ахиулах (5 ба түүнээс дээш өдрийн түрээсийн захиалга өгсөн байх)

- Хөнгөлөлт авахын тулд карт эзэмшигчид тухайн орны урамшууллын купоны (PC) дугаарыг ашиглана.
- Санал нь зөвхөн Европ*, Ази^, АНУ болон Канад дахь оролцогч газруудад Hertz-н боломжит үнээр (leisure жижиглэнгийн худалдааны үнэ) автомашин түрээслэхэд хүчинтэй байна.
- Түрээсийн хугацаа 5 өдрөөс дээш байна.
- Хөнгөлөлтийг дараах автомашины бүлэгт хэрэглэнэ:
 - АНУ/Канадад: жижиг оврын автомашиныг 4 хаалгатай том оврын автомашинтай төстэй стандарт автомашинаар солих
 - Европт*: жижиг оврын автомашиныг 4 хаалгатай том оврын седанаар солих
 - Түрээсийн үед том оврын тээврийн хэрэгсэл байгаа тохиолдолд автомашины ангиллыг үнэ төлбөргүйгээр нэг шатаар ахиулах боломжтой юм.

*Европ: Бельги, Франц, Герман, Итали, Люксембург, Нидерланд, Испани болон Их Британи ^Ази: Бруней, Камбож, Хонг Конг, Малайз, Пакистан, Филиппин, Сингапур, Өмнөд Солонгос, Шри Ланка, Тайвань, Тайланд, Вьетнам.

Үйлчилгээний нөхцөл

Виза үйлчилгээний нөхцөл

Бүх саналын хувьд дараах нөхцөлийг баримтална:

- Энэхүү санал нь зөвхөн Ази Номхон далайн бүс нутагт гаргасан Виза картаар төлбөр хийхэд хүчинтэй юм.
- Хөнгөлөлт авахын тулд CDP#83181-ийг тухайн орны PC#-ийн хамт ашиглана. Санал хэрэгжих нь түрээслэх үед байгаа боломжоос шалтгаална.
- Австрали, Шинэ Зеланд, Европ*, АНУ, Канадад тээврийн хэрэгслийг хүлээн авахаас 24 цагийн өмнө захиалга өгсөн байх ёстой, харин Азид тээврийн хэрэгслийг авахаас 48 цагийн өмнө захиалга өгсөн байна.
- Хорионы (Blackout) хугацааг хэрэглэнэ.
- Санал нь оролцогч газруудад Hertz-н боломжит үнээр (leisure жижиглэнгийн худалдааны үнэ) автомат удирдлагатай автомашин түрээслэхэд хүчинтэй бөгөөд татвар, татварын буцаан олголт, засгийн газрын нэмэлт хураамж буюу шатахуунаар цэнэглэх, GPS сулгах гэх зэрэг нэмэлт үйлчилгээнд хамаарахгүй зөвхөн түрээсийн хугацаа, миль зэрэг зардалд хамаарна.
- Хөнгөлөтийг түрээсийн хугацаа, миль зэрэг зардалд тооцох бөгөөд татвар, хураамж болон нэмэлт үйлчилгээний төлбөрт хэрэглэхгүй.
- Нэг түрээст нэг санал хүчинтэй байна.
- Санал нь Hertz Collections-д хамаарахгүй.
- Түрээслэгч нь 25 ба түүнээс дээш настай байх ба бүх жолооч автомашин хүлээн авах өдрөөс өмнөх 1 жилийн хугацаанд хүчинтэй жолооны үнэмлэхтэй байх ёстой (тодорхой нөхцөлийг харгалзан үзэж болно).
- Автомашин авах болон төлбөр хийх үед хүчинтэй Виза кредит картыг заавал үзүүлнэ.
- Захиалгыг өөрчилсөн тохиолдолд захиалгын үнэ өөрчлөгдөж болзошгүй ба/эсвэл тухайн захиалга цуцлагдаж болзошгүй юм.
- Hertz нь урьдчилан мэдэгдэл гаргахгүйгээр саналыг өөрчлөх ба/эсвэл цуцлах эрхтэй байна.
- Санал нь бэлэн мөнгөний үнэ цэнийг агуулаагүй болно. Тус саналыг аялалын үнэ эсвэл даатгал/дилерийн орлуулах үнэтэй хамт нэг дор ашиглаж болохгүй бөгөөд бусад гэрчилгээ, ваучер, санал буюу урамшуулалтай хослуулан ашиглаж болохгүй.
- Хорио тавих (Blackout) огноог хэрэглэж болно.
- Hertz-н түрээсийн стандарт нөхцөлийг хэрэглэнэ.

- Энэхүү урамшууллын саналыг бусад санал, хөнгөлөлт, купон эсвэл урамшуулалтай нэгтгэж болохгүй.
- Виза нь Hertz-н үзүүлж буй үйлчилгээний аливаа дутагдал, доголдол эсвэл карт эзэмшигчийн аливаа төрлийн хохирлыг ямар ч байдлаар хариуцахгүй.
- Виза карт эзэмшигчид санал болгож буй урамшуулал, хөнгөлөлтийн оронд өөр саналын урамшуулал, хөнгөлөлтийн авч болохгүй бөгөөд аливаа нөхөн төлбөр авах эрхгүй байна. Тухайн саналыг өөр саналаар солих буюу бэлэн мөнгөнд хөрвүүлэх боломжгүй.
- Виза карт эзэмшигчид тухайн саналыг хүлээн авах үүрэг хүлээхгүй. Виза карт эзэмшигчийн аливаа оролцоо нь сайн дурын үндсэн дээр хэрэгжинэ. Аливаа саналыг хүлээн авсан буюу хөнгөлөлт эдлэх оролдлого хийснээр карт эзэмшигч нь энд заасан нөхцөлийг эргэж буцалтгүйгээр хүлээн зөвшөөрч байна.
- Санал болгож буй үйлчилгээг тэр чигээр нь харилцагчдад хүргэхийн тулд Виза хүчин чармайлт гаргах бөгөөд карт эзэмшигчид санал болгосон үйлчилгээг огт үзүүлээгүй эсвэл санал болгосон байдлаар үзүүлээгүй (Hertz эсвэл Визагийн алдаа буюу хайхрамжгүй байдлаас шалтгаалсан) тохиолдолд карт эзэмшигчид Визагийн эсрэг аливаа нэхэмжлэл гаргахгүй, нөхөн төлбөр шаардахгүй болно.
- Виза нь (а) карт эзэмшигчид Hertz-н санал болгож буй аливаа үйлчилгээ авах, авах оролдлого хийх, эсвэл (б) Hertz нь ямар нэгэн шалтгаанаар санал болгосон үйлчилгээг үзүүлэхээс татгалзах, үзүүлэх боломжгүй байх, тус үйлчилгээтэй холбоотой хөнгөлөлт, давуу эрхийг олгохоос татгалзах, эсхүл олгохгүй байх зэргээс шалтгаалан гарч болох аливаа алдагдал, хохирлыг ямар ч байдлаар хариуцахгүй болно.
- Виза нь урьдчилан мэдэгдэл гаргахгүйгээр, хэдийд ч аливаа саналын хугацаа, нөхцөлийг цуцлах болон/эсвэл өөрчлөх бүрэн эрхтэй болно.
- Бусад хязгаарлалтыг хэрэглэж болно.

Rentalcars.com-н санал:

• Өөрөөр заагаагүй бол энэхүү урамшууллыг бусад санал, хөнгөлөлт эсвэл урамшуулалтай хослуулан ашиглаж болохгүй. Хөнгөлөлт нь зөвхөн автомашины түрээсийн үнэд хамаарах бөгөөд татвар, хураамж, нэмэлт хураамж, автомашиныг авах, буцаан өгөх газар нь өөр тохиолдолд төлөх хураамж (one-way fees), хүүхдийн суудал, жолооч, шатахуун зэрэгтэй холбоотой нэмэлт төлбөрт хөнгөлөлт үзүүлэхгүй. Бүх түрээсийн хувьд стандарт нөхцөл болон автомашин түрээслэгч компанийн үйлчилгээний нөхцөлийг ("Түрээсийн бүрэн нөхцөл") хэрэгжүүлнэ (түрээслэгч компанийн үйлчилгээний нөхцөлийг "Options" хуудсаас харж болно). Цахим хуудсанд хөнгөлөлттэй үнийг харуулсан байгаа. Урамшууллын хугацаанд автомашины нөөц хязгаарлагдмал тул бүх саналууд нь тухайн үеийн боломжоос хамаарна. Түрүүлж ирсэн нь түрүүлж үйлчилгээ авна гэсэн зарчмаар захиалгыг баталгаажуулдаг байна.

Rentalcars.com-н үйлчилгээний нөхцөлтэй холбоотой мэдээллийг <https://www.rentalcars.com/en/terms/> холбоосоор авч болно.

Үйлчилгээний нөхцөл

Value Retail-н санал:

- Виза карт эзэмшигчдэд 2022 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэл хүчинтэй; Худалдан авалтын 10%-ийн хэмнэлт;
- Хэмнэсэн 10%-иа буцаан авахын тулд VIP Pass татаж аваад, QR кодыг eWallet-д нэмж оруулан оролцогч нэрийн дэлгүүр/бутик, ресторанд харуулаарай.
- Оролцогч нэрийн дэлгүүр/бутик, ресторанд Village үнийг хямдруулна.
- Энэхүү урамшууллыг бусад саналтай хослуулан ашиглах боломжгүй. Үйлчилгээний нөхцөлтэй бүрэн танилцахын тулд энд дарна уу. Хувийн люкс өрөө, байранд орохоос 48 цагийн өмнө захиалга өгөх ёстой (тус саналын хэрэгжилт боломжтой эсэхээс хамаарна).
- Та тухайн тосгонтой Виртуал Худалдаа авахын тулд тухайн тосгон байрладаг улсын оршин суугч байх ёстойг анхаарна уу.
- Та тухайн Village-н виртуал худалдааны үйлчилгээнд хамрагдахын тулд тухайн Village байрладаг улсын оршин суугч байх ёстойг анхаарна уу.

Нисэх онгоцны буудлын Ногоон гарцын санал:

Виза үйлчилгээний хугацаа, нөхцөл

Ерөнхий нөхцөл:

- Тус санал нь 2019/01/01 - 2022/12/31 хугацаанд хүчинтэй байна.
- Зөвхөн Platinum, Signature болон Infinite Виза карт эзэмшигчид тус эрхийг эдэлнэ.
- Онлайн захиалгыг speedpass.yqnowgroup.com цахим хуудсаар хийнэ.
- Төлбөрийг Ази Номхон далайн бүс нутагт гаргасан Platinum, Signature эсвэл Infinite Виза картаар хийх ёстой.
- Захиалга хэрэгжилт нь боломжтой эсэхээс хамаарна.
- Үйлчилгээний захиалгыг аялал эхлэхээс 72 цагийн өмнө өгсөн байх ёстой.
- Тус саналыг бусад урамшуулалтай хамт ашиглаж болохгүй.
- Үйлчилгээний нөхцөл хэрэгжинэ. Дэлгэрэнгүй мэдээллийг speedpass.yqnowgroup.com цахим хуудсаас авна уу.
- Санал болгож буй үйлчилгээг тэр чигээр нь харилцагчдад хүргэхийн тулд Виза хүчин чармайлт гаргах бөгөөд карт эзэмшигчид санал болгосон үйлчилгээг огт үзүүлээгүй эсвэл санал болгосон байдлаар үзүүлээгүй (yQ (Meet & Assist) FZE эсвэл Визагийн алдаа буюу хайхрамжгүй байдлаас шалтгаалсан) тохиолдолд карт эзэмшигчид Визагийн эсрэг аливаа нэхэмжлэл гаргахгүй, нөхөн төлбөр шаардахгүй болно.
- (a) Карт эзэмшигчид yQ (Meet & Assist) FZE-н санал болгож буй аливаа үйлчилгээ авах, авах оролдлого хийх, эсвэл (б) yQ (Meet & Assist) FZE нь ямар нэгэн шалтгаанаар санал болгосон үйлчилгээг үзүүлэхээс татгалзах, үзүүлэх боломжгүй байх, тус үйлчилгээтэй холбоотой хөнгөлөлт, давуу эрхийг олгохоос татгалзах, эсхүл олгохгүй байх зэргээс шалтгаалан гарч болох аливаа алдагдал, хохирлыг Виза нь ямар ч байдлаар хариуцахгүй болно.
- Виза нь урьдчилан мэдэгдэл гаргахгүйгээр, хэдийд ч аливаа саналын хугацаа, нөхцөлийг цуцлах болон/эсвэл өөрчлөх бүрэн эрхтэй болно.

Захиалгын цуцлалт, хураамж:

- Захиалгыг цуцлах тухай мэдэгдлийг 48 цагаас бага хугацаанд өгч, хүрэлцэн ирээгүй тохиолдолд тухайн үйлчилгээг авсан гэж үзнэ.

Санамж:

Энэхүү танилцуулах материалыг Англи хэлээс Монгол хэл рүү орчуулсан тул эх хувьтай танилцахыг хүсвэл [энд дарна уу.](#)